



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Налайх дүүргийн Татварын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2024/92/НА-СА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн хэлтсийн дарга Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Ё.Лхагвадулам Утас: 325093 Цахим хаяг: lkhagvadulamyо@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Нэг.Хараат бус аудиторын дүгнэлт



НАЛАЙХ ДҮҮРГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГА Ц.АЛТАНЦООЖ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.02.2 № 66
танай -ны № -т

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Налайх дүүргийн Татварын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Налайх дүүргийн Татварын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой онцлог асуудлуудыг нэгтгэн харуулав. Үүнд:

Тайлант онд улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөө 21,760.2 мянган төгрөгөөр 118.2 хувиар давж биелсэн.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь дүүргийн Засаг даргын захирамжаар 2023 онд эзэмших эрхтэй олгосон 1,500 м.кв газрыг бүртгэлд тусгаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 92.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭ
АУДИТОР



ЭРДЭНЭЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>24,641,526.22</u>	<u>30,003,931.90</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	00.00	00.00
33	АВЛАГА	00.00	724,589.90
33402	Татвар, НДШ – ийн авлага	00.00	724,589.90
34	УРЬДЧИЛГАА	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	24,641,526.22	29,279,342.00
354	Хангамжийн материал	24,641,526.22	29,279,342.00
35410	Бичиг хэргийн материал	5,211,375.00	9,856,592.00
35420	Аж ахуйн материал	17,947,600.00	18,422,750.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,482,551.22	1,000,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	00.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>123,956,955.39</u>	<u>98,334,952.07</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	00.00	00.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	123,956,955.39	98,334,952.07
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	97,023,705.39	71,401,702.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	44,017,333.40	44,017,333.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	-18,928,642.95	-23,657,564.70
39203	Авто-тээврийн хэрэгсэл	38,000,000.00	38,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-22,800,000.00	-37,339,355.22
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	114,538,066.06	88,381,208.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	-78,518,486.86	-64,634,023.50
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,474,833.71	29,332,855.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,472,332.76	-7,401,593.57
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,233,220.00	6,327,720.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,584,285.21	-1,688,878.26
39217	Ном	64,000.00	64,000.00
393	Биет бус хөрөнгө	26,933,250.00	26,933,250.00
39303	Бусад биет бус хөрөнгө	26,933,250.00	26,933,250.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>148,598,481.61</u>	<u>128,338,883.97</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>7,197,100.35</u>
4136	Бусад өглөг	00.00	7,197,100.35
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	00.00	7,197,100.35
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	148,598,481.61	121,141,783.62
51	Засгийн газрын хувь оролцоо	148,598,481.61	121,141,783.62
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	204,276,788.27	204,276,788.27
51101	Өмч: - төрийн	204,276,788.27	204,276,788.27
512	Хуримтлагдсан үр дүн	-109,421,793.05	-136,878,491.04
51210	Өмнөх үеийн үр дүн	-92,632,162.90	-112,569,241.05
51220	Тайлант үеийн үр дүн	-16,789,630.15	-24,309,249.99
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	53,743,486.39	53,743,486.39
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	148,598,481.61	128,338,883.97

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	535,251,161.08	900,391,606.86
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,083,161.08	8,069,781.86
120	Нийтлэг татварын бус орлого	14,083,161.08	8,069,781.86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,083,161.08	737,892.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	14,083,161.08	737,892.00
120009	Бусад орлого	00.00	7,331,889.86
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	524,168,000.00	892,321,825.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	447,068,000.00	701,477,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	447,068,000.00	701,477,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,000,000.00	20,844,625.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,000,000.00	20,844,625.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71,100,000.00	170,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	71,100,000.00	170,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	555,040,791.23	923,648,185.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	555,040,791.23	923,648,185.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	546,991,421.23	841,012,588.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	329,432,094.00	506,983,826.45
210101	Үндсэн цалин	329,432,094.00	506,983,826.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,036,583.00	131,029,257.42
210201	Тэтгэврийн даатгал	84,036,583.00	131,029,257.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,422,830.00	23,668,147.28

210301	Гэрэл, цахилгаан	3,913,291.00	5,439,158.28
210302	Түлш, халаалт	13,901,489.00	17,434,579.00
210303	Цэвэр, бохир ус	1,438,050.00	794,410.00
210304	Байрны түрээс	1,170,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,638,296.50	39,115,897.22
210401	Бичиг хэрэг	923,060.00	27,397,826.22
210402	Тээвэр, шатахуун	4,034,000.00	6,949,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,967,300.00	2,640,079.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	746,000.00	850,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,967,936.50	1,278,992.00
2105	Нормативт зардал	00.00	348,000.00
210502	Хоол, хүнс	00.00	348,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,360,000.00	78,018,623.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	21,788,399.00
210604	Урсгал засвар	9,360,000.00	56,230,224.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	64,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	64,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,217,300.00	19,840,615.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,588,000.00	18,902,799.00
210803	Даатгалын үйлчилгээ	424,000.00	650,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	197,100.00	279,600.00
210807	Газрын төлбөр	8,200.00	8,216.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,884,317.73	41,944,221.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,369,633.92	858,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	728,000.00	1,620,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,786,683.81	39,466,221.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,049,370.00	82,635,597.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,420,000.00	40,650,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,420,000.00	40,650,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,629,370.00	41,985,597.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,629,370.00	41,985,597.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-16,789,630.15	-23,256,578.70
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	1,052,671.29
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	1,052,671.29
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-1,052,671.29
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-16,789,630.15	-24,309,249.99

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	524,168,000.00	892,321,825.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	524,168,000.00	892,321,825.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	447,068,000.00	701,477,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	447,068,000.00	701,477,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,000,000.00	20,844,625.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,000,000.00	20,844,625.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71,100,000.00	170,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	71,100,000.00	170,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	524,168,000.00	884,756,825.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	524,168,000.00	884,756,825.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	516,118,621.00	802,121,227.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	368,243,842.00	566,253,618.02
210101	Үндсэн цалин	220,876,541.00	275,381,122.59
210102	Нэмэгдэл	52,192,749.00	85,506,447.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,998,589.00	32,227,744.29
210104	Урамшуулал	61,175,963.00	173,138,303.59
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,224,835.00	67,115,769.40
210201	Тэтгэврийн даатгал	31,823,818.81	50,089,227.91
210202	Тэтгэмжийн даатгал	3,487,844.33	5,401,344.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,790,275.41	4,317,016.05
210204	Ажилгүйдлийн даатгал	619,371.84	1,049,594.92
210205	Эрүүл мэндийн даатгал	6,503,524.61	6,258,586.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,388,830.00	23,668,147.28
210301	Гэрэл, цахилгаан	3,913,291.00	5,439,158.28
210302	Түлш, халаалт	13,901,489.00	17,434,579.00
210303	Цэвэр, бохир ус	1,404,050.00	794,410.00
210304	Байрны түрээс	1,170,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,726,214.00	46,548,025.00
210401	Бичиг хэрэг	16,654,614.00	17,013,129.00
210402	Тээвэр, шатахуун	8,255,900.00	7,420,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,919,724.00	2,709,779.00
210404	Ном, хэвлэл	47,576.00	00.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	1,030,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,128,400.00	18,375,117.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	737,200.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,871,100.00	59,264,053.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,725,900.00	249,500.00
210602	Тавилга	7,500,000.00	00.00
210604	Урсгал засвар	10,645,200.00	59,014,553.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	64,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	64,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,321,300.00	30,782,615.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,588,000.00	30,024,799.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	390,400.00	380,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	312,700.00	279,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	8,200.00	32,716.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,605,300.00	8,425,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	55,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,605,300.00	8,370,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,049,379.00	82,635,597.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,420,000.00	40,650,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,420,000.00	40,650,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,629,379.00	41,985,597.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,629,379.00	41,985,597.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	7,565,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	7,565,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	7,565,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	7,565,000.00
223001	Бусад хөрөнгө	00.00	7,565,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-7,565,000.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00

7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	204,276,788.27	53,743,486.39	-92,632,162.90	165,388,111.76
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	204,276,788.27	53,743,486.39	-92,632,162.90	165,388,111.76
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-16,789,630.15	-16,789,630.15
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	204,276,788.27	53,743,486.39	-109,421,793.05	148,598,481.61
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	204,276,788.27	53,743,486.39	-109,421,793.05	148,598,481.61
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-3,147,448.00	-3,147,448.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	204,276,788.27	53,743,486.39	-112,569,241.05	145,451,033.61
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-24,309,249.99	-24,309,249.99
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	204,276,788.27	53,743,486.39	-136,878,491.04	121,141,783.62

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	тоо	хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	701,477,200.00	659,491,703.18	41,985,496.82	94.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	701,477,200.00	659,491,703.18	41,985,496.82	94.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	699,827,200.00	657,841,703.18	41,985,496.82	94.0

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	566,879,000.00	533,793,866.50	33,085,133.50	94.2
210101	Үндсэн цалин	273,379,300.00	255,494,370.07	17,884,929.93	93.5
210102	Нэмэгдэл	106,948,100.00	85,506,447.55	21,441,652.45	80.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,108,600.00	32,227,744.29	7,880,855.71	80.4
210104	Урамшуулал	146,443,000.00	160,565,304.59	14,122,304.59	109.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,859,900.00	62,609,807.40	8,250,092.60	88.4
210201	Тэтгэврийн даатгал	48,184,700.00	45,583,265.91	2,601,434.09	94.6
210202	Тэтгэмжийн даатгал	5,668,800.00	5,401,344.33	267,455.67	95.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,535,100.00	4,317,016.05	218,083.95	95.2
210204	Ажилгүйдлийн даатгал	1,133,700.00	1,049,594.92	84,105.08	92.6
210205	Эрүүл мэндийн даатгал	11,337,600.00	6,258,586.19	5,079,013.81	55.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,067,200.00	23,668,147.28	399,052.72	98.3
210301	Гэрэл, цахилгаан	5,775,300.00	5,439,158.28	336,141.72	94.2
210302	Түлш, халаалт	17,234,400.00	17,434,579.00	-200,179.00	101.2
210303	Цэвэр, бохир ус	1,057,500.00	794,410.00	263,090.00	75.1
2104	Хангамж, бараа материалын зардал	10,663,200.00	10,662,317.00	883.00	100.0
210401	Бичиг хэрэг	2,760,000.00	3,179,360.00	-419,360.00	115.2
210402	Тээвэр, шатахуун	360,000.00	320,000.00	40,000.00	88.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,293,200.00	2,540,440.00	752,760.00	77.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	750,000.00	1,030,000.00	-280,000.00	137.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,500,000.00	3,592,517.00	-92,517.00	102.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,485,950.00	14,050.00	99.1
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,485,950.00	14,050.00	99.1
2107	Томилолт, зочны зардал	300,000.00	64,000.00	236,000.00	21.3
210702	Дотоод албан томилолт	300,000.00	64,000.00	236,000.00	21.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,002,900.00	21,002,615.00	285.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,245,000.00	20,244,799.00	201.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	380,000.00	380,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	279,100.00	279,100.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	32,800.00	32,716.00	84.00	99.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,555,000.00	4,555,000.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,000.00	55,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,500,000.00	4,500,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,650,000.00	1,650,000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,650,000.00	1,650,000.00	0.00	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,650,000.00	1,650,000.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	701,477,200.00	659,491,703.18	41,985,496.82	94.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	701,477,200.00	659,491,703.18	41,985,496.82	94.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	701,477,200.00	659,491,703.18	41,985,496.82	94.0

62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22	21	1.00	95.5
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	18	17	1.00	94.4
620003	Үйлчлэх ажилтан	3	3	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	190,844,625.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	190,844,625.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	151,844,625.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	33,744,864.52
210101	Үндсэн цалин	21,171,864.52
210104	Урамшуулал	12,573,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,539,484.00
210201	Тэтгэврийн даатгал	4,539,484.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,135,708.00
210401	Бичиг хэрэг	16,507,208.00
210402	Тээвэр, шатахуун	7,100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,528,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	64,024,568.48
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,814,500.00
210604	Урсгал засвар	56,210,068.48
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,780,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,780,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,620,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,620,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	39,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	190,844,625.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	190,844,625.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	170,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,844,625.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 67,227.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Цалингаас суутгасан ХХОАТ-ын дутуу төлөлт 7,197.1 мянган төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тайлагнаагүй. Энэ нь УСНББОУС-20 холбоотой талуудын тодруулга, УСНББОУС-24 төсвийн мэдээллийн толилуулга болон санхүүгийн тайлангийн “оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Мөнгөн гүйлгээний тайланд 7,565.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж авсныг биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлаар тайлагнаагүй. Энэ нь УСНББОУС-24 төсвийн мэдээллийн толилуулга болон санхүүгийн тайлангийн “толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд 41,985.6 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг илүү тайлагнасан. Энэ нь УСНББОУС-24 төсвийн мэдээллийн толилуулга болон санхүүгийн тайлангийн “толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Өмнөх оны нийгмийн даатгалын шимтгэлийн дутуу төлөлт 3,147.4 мянган төгрөгийг санхүүгийн тайланд залруулаагүй. Энэ нь УСНББОУС-20 холбоотой талуудын тодруулга, УСНББОУС-24 төсвийн мэдээллийн толилуулга болон санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 7,331.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлэн орлогод авахдаа данснаас хасахгүйгээр хөрөнгийн дахин үнэлгээг нэмэгдүүлсэн. Энэ нь УСНББОУС-24 төсвийн мэдээллийн толилуулга болон санхүүгийн тайлангийн “толилуулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 10,848.9 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 813.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 10,035.6 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1 Төлбөрийн акт

Татварын зарим улсын байцаагч нарт татварын улсын байцаагчийн үр дүнгийн шагнал олгохдоо тушаалд заасан хувиас илүү тооцож 813.3 мянган төгрөгөөр илүү олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”; Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 “*Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно*” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Дүүргийн засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/228 дугаартай захирамжаар эзэмшүүлэх эрхтэйгээр олгосон (1,500 м.кв хэмжээ бүхий Э*2207009889 бүртгэлтэй) газрыг бүртгэлд аваагүй нь санхүүгийн тайланд хөрөнгө дутуу тайлагнагдах үр дагаварт хүргэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “*үнэн зөв байх*,” заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын нэр дээр эзэмшүүлэх эрхтэй олгосон газрыг санхүүгийн бүртгэлд тусгах

2. Урсгал зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нэмэлт санхүүжилтийн данснаас анхан шатны бүрдэл дутуу баримтаар 7,695.0 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн нь хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сулрахад хүргэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “*үнэн зөв байх*”, 13 дугаар зүйлийн 13.1 “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны бүрдэл болсон баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэлд гүйлгээ хийж байх.

Илрүүлэлт: Зарим ажилтны цалингаас 1,616.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг илүү суутгасан нь нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан алдаатай тайлагнагдах үр дагаварт хүргэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “*үнэн зөв байх*” заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилтан албан хаагчдын цалингаас нийгмийн даатгалын шимтгэлийг хууль, журамд заасны дагуу үнэн зөв суутгаж байх.

3. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын шимтгэл илүү төлж 724.6 авлага үүсгэсэн нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулахгүй төсвийн зарцуулалтад тавих хяналт сулрах үр дагаварт хүргэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"* заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлагыг барагдуулах, төсвийг зохистой удирдаж авлага үүсгэхгүй байх, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

"NISSAN TEANA" маркийн суудлын авто машины улсын дугаарыг цэнхэр дэвсгэрээр солиогүй байна. Энэ нь Стандарт, хэмжилзүйн газрын даргын баталсан "MNS 4410-1-2002, Авто тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг, 1-р хэсэг : Ерөнхий шаардлага стандартын 5.4.9 дэх заалт *"Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй авто тээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр нь хар хөх, тоо, үсэг ба хүрээ нь цагаан өнгөтэй байна"* заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: "NISSAN TEANA" маркийн авто машины улсын дугаарыг цэнхэр дэвсгэрээр сольж ашиглах хүсэлтийг холбогдох байгууллагад гаргаж шийдвэрлүүлэх зөвлөмж өглөө.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Нийслэлийн Налайх дүүргийн Татварын хэлтэс нь 2023 онд нийт 1,115,734.0 мянган төгрөгийн 38 мэдээллийг байршуулахаас 263,358.5 мянган төгрөгийн 12 мэдээллийг бүрэн байршуулж, 852,375.5 мянган төгрөгийн 26 мэдээллийг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 690,785.5 мянган төгрөгийн орлогын 13 гүйлгээ, 80,985.5 мянган төгрөгийн зарлагын 2 гүйлгээ, хөрөнгө мөнгө зарцуулах тухай 80,604.5 мянган төгрөгийн 11 шийдвэрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4. *"Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ."* 6.4.5. *"цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;"* 6.4.8. *"бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;"* заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулж, биелэлтийг ирүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Цалингаас суутгасан ХХОАТ-ын дутуу төлөлтийг санхүүгийн тайланд өглөгөөр тайлагнаагүй	1	7,197.1			1	7,197.1	1	7,197.1				
Мөнгөн гүйлгээний тайланд худалдаж авсан үндсэн хөрөнгийг биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлаар тайлагнаагүй	1	7,565.0			1	7,565.0	1	7,565.0				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг илүү тайлагнасан	1	41,985.6			1	41,985.6	1	41,985.6	-	-	-	-
Өмнөх оны нийгмийн даатгалын шимтгэлийн дутуу төлөлтийг санхүүгийн тайланд залруулаагүй	1	3,147.4			1	3,147.4	1	3,147.4				
Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлэн орлогод авахдаа данснаас хасахгүйгээр хөрөнгийн дахин үнэлгээг нэмэгдүүлсэн	1	7,331.9			1	7,331.9	1	7,331.9				
Дүн	5	67,227.0	-	-	5	67,227.0	5	67,227.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	/мянган төгрөгөөр/ Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад

											шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүүргийн ЗД-ын захирамжаар эзэмшүүлэх эрхтэйгээр олгосон газрыг бүртгэлд аваагүй	1						1					
Татварын зарим улсын байцаагч нарт татварын улсын байцаагчийн үр дүнгийн шагнал олгоходоо тушаалд заасан хувиас илүү бодож олгосон	1	813.3	1	813.3								
Зарим ажилтны цалингаас нийгмийн даатгалын шимтгэлийг илүү суутгасан	1	1,616.0					1	1,616.0				
Анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн	1	7,695.0					1	7,695.0				
Нийгмийн даатгалын шимтгэл илүү төлж авлага үүсгэсэн	1	724.6					1	724.6				
Дүн	5	10,848.9	1	813.3			4	10,035.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Үйл ажиллагаандаа ашиглаж байгаа "Nissan teana" маркын суудлын авто машины улсын дугаарыг цэнхэр дэвсгэрээр солиогүй	1							1	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны цахим хуудсанд 26 мэдээлэл байршуулаагүй	1	852,375.5			1	852,375.5			
Дүн	2	852,375.5	-	-	1	852,375.5	1		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			